




КАМЕР ХЯНАЛТЫН ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь БПК-ийн хичээлийн байр, дадлагын газар, оюутны дотуур байр, барилга байгууламжийн гадна, дотор орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж байгаа хяналтын камер, түүнийг ашиглахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Үндсэн хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, стандартуудыг мөрдлөг болгоно.

Хоёр. Дүрс бичлэгийн техник, хэрэгсэлд тавигдах шаардлага

2.1. Нэгдсэн системд холбогдсон, эсхүл нэг бүрийн зориулалттай, хууль сахиулах ажиллагаанд шаардлагатай нотлох баримт болох дууны, дүрсний, дуу-дүрсний мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах боломж бүхий хөдөлгөөнт болон суурин дүрс бичлэгийн техник, хэрэгсэл нь Монгол Улсын "Барилга, орон сууц, сургууль, гудамж талбайд тавих хяналтын камер, Ерөнхий шаардлага /MNS 6423:2013/, Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага /MNS6423:2019/ нийцэхээс гадна дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 2.1.1. Дүрсний нягтаршил HD1080 мегапикселээс багагүй байх;
- 2.1.2. Харанхуйд бичлэг хийх чадвартай байх;
- 2.1.4. Төхөөрөмж нь нэг секундэд 24 болон түүнээс дээш /frame/ зураг авах, дууг 128 bitrate /kb/s/ болон түүнээс дээш үзүүлэлтээр бичлэг хийх боломжтой байх;
- 2.1.5. хүний царай зүс, гадаад дүр төрх, содон шинж тэмдгийг татаж томруулах боломжтой байх;
- 2.1.6. нэгдсэн системд холбогдсон төхөөрөмж нь 168, нэг бүрийн төхөөрөмж нь 72 цагаас багагүй хугацаанд мэдээллийг хадгалах багтаамжтай байх;
- 2.1.7. газар хөдлөлтийн 8 баллд болон -40° хэмээс $+40^{\circ}$ хэмд тэсвэртэй байх;
- 2.1.8. камер, бичлэгийн төхөөрөмжийн тохиргооны горим нь англи болон монгол хэлтэй байх;
- 2.1.9. шилэн кабелийн сүлжээний хурд нь хандалт хийх камерыг хамгийн багадаа HD720 Мегапиксел дүрсний нягтралаар харах нөхцөлийг хангасан байх;
- 2.1.10. тоон технологид суурилсан /IP/ камерын систем нь сүлжээний хаягжилт хийж, тохируулах боломжтой байх;
- 2.1.11. мэдээлэл, өгөгдөл, түүнийг дэмжих дэд бүтцийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан байх.

Гурав. Дүрс бичлэгийн техник, хэрэгслийг хэрэглэх

3.1. Дүрс бичлэгийн техник, хэрэгслийг Барилгын Политехник Коллежийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад ашиглана.

3.2. Хяналтын камерыг хуульд хориглосноос бусад газарт байршуулах бөгөөд байршуулсан схемийг нэгж бүр мэдээллийн самбарт олон нийтэд нээлттэй байршуулна.

3.3. Хичээлийн болон дадлагын байрны гадна, дотор хяналтын камерын хэвийн ажиллагааг цахим тоног төхөөрөмж, мэдээллийн сан сүлжээ хариуцсан ажилтан, оюутны дотуур байрны байрлах хяналтын камерыг дотуур байрны багш хариуцаж ажиллана.

3.4. Камер хариуцсан ажилтнууд нь хяналтын бичлэг бусад тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж, шаардлагатай тохиолдолд хяналтын камерын бичлэгийг захирлын зөвшөөрлөөр багш, ажилтан, суралцагч, цагдаагийн байгууллагын албан хүсэлтийг үндэслэн ажлын 2 хоногт шүүж, хуулбарлаж өгнө.

3.5. Мэдээллийг хадгалах, хуулбарлах, олшруулах үед мэдээлэл болон мэдээллийн системд зөвшөөрөлгүй хандах, мэдээллийг ашиглах, ил болгох, өөрчлөх, хуулах, устгах, мэдээллийн системийн үйл ажиллагааг тасалдуулах, хянахаас хамгаалах зэргээр мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангах арга хэмжээг заавал авна.

3.6. Хяналтын камерын системд хандах давуу эрхийг хязгаарлах, хандалтыг таслах, тоног төхөөрөмжийн холбогт, тохиргоог өөрчлөх, камер, бичлэгийн тоног төхөөрөмжийн сүлжээний хаягжилтыг өөрчлөх, зөвшөөрөлгүйгээр иргэнээр хандалт тохируулах зэргийг хориглоно.

Дөрөв. Шинээр хяналтын камер байрлуулах

4.1. Хяналтын камерын техник, хэрэгслийг шинээр байршуулах тохиолдолд тухайн жилийн төсөвт суулгаж, камер байршуулах цэгийг тодорхой болгож "Барилга, орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер, ерөнхий шаардлага /MNS 6423:2013, Теле хяналтын системийн тенхикийн ерөнхий шаардлага /MNS 6423:2019/-ын дагуу төлөвлөнө.

4.2. Хяналтын камерын техник, хэрэгслийг шинээр байрлуулах ажилд Захиргаа, аж ахуйн алба хяналт тавих ба тухайн жилийн төсөвт тусгаж буй тоо, ширхэг, үзүүлэлтийг стандартад нийцүүлэн ажиллана.

Тав. Хариуцлага

5.1. Хяналтын камер, холбогдох тоног төхөөрөмжид багш, ажилтан, оюутан суралцагчид санаатай болон санамсаргүй үйлдэл /шингэн зүйл асгах, гаднын биетээр гэмтээх, богино холболт үүсгэх, холбогч утасыг салгах, үзэгдэх орчныг хязгаарлах, тэжээлийн утасыг салгах/-ээр эвдрэл, гэмтэл учруулбал буруутай этгээд хэвийн ажиллагаагүй болсноос үүсэх зардал болон хохирлыг барагдуулах үүрэгтэй. Буруутай этгээдэд захиргааны болон сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

5.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмын дагуу хариуцлага тооцно.